



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 11/323

Улаанбаатар хот

Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 93,247,047.90 (ерэн гурван сая хоёр зуун дөчин долоон мянга дөчин долоон төгрөг ерэн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэг (Ж.Алтан-Од)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 10 нэр төрлийн 3,967,225.90 (гурван сая есөн зуун жаран долоон мянга хоёр зуун хорин таван төгрөг ерэн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 8 нэр төрлийн 89,279,822 (наян есөн сая хоёр зуун далан есөн мянга найман зуун хорин хоёр) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 220,000 (хоёр зуун хорин мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 66,000 (жаран зургаан мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэг (Ж.Алтан-Од)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000941



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 152 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-мэргэжилтний дүгнэлт	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Уурын зуух нам даралт	8	ш	1	55,000,000.0	55,000,000.0	41,250,000.0	13,750,000	ЗУУХНЫ ШИНЭЧЛЭЛТ	актлах	100,000	100,000	100,000
2	Тоос сорогч	9	ш	4	100,000.0	400,000.0	400,000.0	-	Эвдэрсэн	актлах	устгах	устгах	устгах
3	Гагнуурын аппарат	11	ш	1	271,350.0	271,350.0	271,350.0	-	Эвдэрсэн	актлах	3000	3000	3000
4	Хөлдөөгч	11	ш	1	342,300.0	342,300.0	342,300.0	-	Эвдэрсэн	актлах	5000	5000	5000
5	Олон үйлдэлт принтер	5	ш	1	302,500.0	302,500.0	302,500.0	-	Эвдэрсэн	актлах	устгах	устгах	устгах
6	Зургын аппарат	4	ш	1	250,000.0	250,000.0	250,000.0	-	Эвдэрсэн	актлах	устгах	устгах	устгах
7	Тоосонцор барих төхөөрөмж	1	ш	1	33,000,000.0	33,000,000.0	8,800,000.0	24,200,000	ЗУУХНЫ ШИНЭЧЛЭЛТ	актлах	100,000	100,000	100,000
8	Оёдлын машин	11	ш	1	217,080.0	217,080.0	217,080.0	-	Эвдэрсэн	актлах	10,000	10,000	10,000
9	Цахилгаан хөгжим Ямаха	11	ш	1	380,350.0	380,350.0	380,350.0	-	Эвдэрсэн	актлах	1,000	1,000	1,000
10	Компьютер	11	ш	1	800,000.0	800,000.0	800,000.0	-	Эвдэрсэн	актлах	устгах	устгах	устгах
11	Компьютер	9	ш	2	615,000.0	1,230,000.0	1,230,000.0	-	Эвдэрсэн	актлах	устгах	устгах	устгах
	Дүн				91,278,580.0	92,193,580.0	54,243,580.0				219,000	219,000	219,000
Тавилга эд хогшил													
12	3 хос төмөр сандал	11	ш	2	290,000.0	580,000.0	580,000.0	-	Эвдэрсэн	актлах	устгах	устгах	устгах
13	Коридорын дугуй ширээ	11	ш	1	36,180.0	36,180.0	36,180.0	-	Эвдэрсэн	актлах	500	500	500
14	Коридорын дрож	11	ш	4	11,912.0	47,648.0	47,648.0	-	Эвдэрсэн	актлах	устгах	устгах	устгах

15	Кресло сандал	11	ш	2	16,281.0	32,562.0	32,562.0	-	Эвдэрсэн	актлах	500	500	500
16	Цахилгаан дринл	11	ш	1	67,077.9	67,077.9	67,078.0	-	Эвдэрсэн	актлах	устгах	устгах	устгах
17	Зурагт Дүн	11	ш	1	110,000.0	110,000.0	110,000.0	-	Эвдэрсэн	актлах	устгах	устгах	устгах
					531,450.9	873,467.9	873,468.0				1,000	1000	1000
Биет бус хөрөнгө													
18	Өмчийн программ Дүн	10	ш	1	180,000.0	180,000.0	180,000.0	-	ашиглалтгүй	актлах	устгах	устгах	устгах
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн					180,000.0	180,000.0	180,000.0						
Үүнээс: Худалдах хөрөнгө					93,247,047.9	93,247,047.9	55,297,047.9	37,950,000					
Устгах хөрөнгө					89,279,822.0	89,279,822.0							
Худалдсанаас олох орлого					3,967,225.9	3,967,225.9							
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/					220,000	220,000							
					66,000	66,000							